

Living the

LOTUS

Buddhism in Everyday Life

3
2017

VOL. 138

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ҮГ

Хүндэлж биширч явдаг хүний ганцхан үгний хүч

“Энэ хүний хэлсэн үг бол гарцаагүй үнэн байх учиртай гэх чин сэтгэлээсээ хүндэлж биширдэг хүнтэй байх нь том аз” гэж хэлэх хүн байдаг. Би ч гэсэн үүнтэй санал нэгтэй байна.

Хэлсэн үг бүрийг “үнэхээр тийм” гэж толгой дохин хүлээж авч чадах тийм л хүн. Мөн царайг нь харах, хоолойг нь сонсох төдийд л баярлаж, амьдрах эрч хүч оргилон гарч ирдэг. “Би ч гэсэн ийм л хүн болмоор байна” гэж бодож байтал, өөрийн мэдэлгүй ярих байдал, бодол санаа хүртэл нөгөө хүнтэйгээ ижилхэн болоод ирдэг.

Шашин шүтлэг ч ялгаагүй. Гишүүд та бүгдийн олонх нь бурханы сургаалд татагдан элссэн нь яриангүй үнэн боловч анх элсүүлсэн хүн, хэсгийн ахлагч, тэргүүн гэх зэрэг хүмүүсийн байгаа байдалд

татагдан сургаалын зам мөрт ороогүй гэж үү. Тэр хүний айлдсан сургаал болохоор л чин сэтгэлээсээ сонсож, аажим аажмаар бурханы сургаалын гүн лүү татагдан орсон болов уу гэж бодож байна.

Компанид ч гэсэн доод тушаалын ажилчиддаа хүндлэгдэнэ гэдэг дарга хүний хувьд хамгийн нэгдүгээрх үзүүлэлт болдог. Сэтгэлээсээ тэр хүнийг хүндэлдэг болвол өөрт хандаж ганц үг хэлэх төдийд л баярлаж хөөрнө. Алдаа гаргаж, анхааруулга авбал “итгэлийг нь алдаж болдоггүй юм шүү” гэж өөрийгөө дайчилна. Зааварчилгаа өгөхийн өмнө нь өөрөө анзаарч түрүүлж хөдлөх болно.

Хүмүүсээр хүндлүүлдэг хүн болвол дуугүй байсан ч бусдыг аврах чадвартай болно.

Үүсгэн байгуулагчийн үг 9, X166-167

Living the Lotus
Vol. 138 (2017.3)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Мизүтани Шёокоо

Орчуулсан: Б.Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Эерэг байх уу сөрөг байх уу

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Эерэг эрч хүч нь урагш тэмүүлэх хүчийг өгнө

Хүний нас нэмэхтэй зэрэгцээд биед нь өөрчлөлт гардаг бололтой. Би ч гэсэн өвдөлт, түүнээс улбаатай бага зэргийн тухгүй байдлыг сүүлийн үед биеэрээ мэдэрч байгаа ба ийм байдлаас хурдан салахсан гэж бодсон ч тийм амар салж чадахгүй. Ийм үед бидний хандлага “хэцүү байна”, “өвдөж байна”, “хурдан хуучин хэвэндээ орохсон” гэсэн одоогийн бодит байдлыг үгүйсгэх тал руу чиглэдэг.

Биеийн өвдөлтөөр зогсохгүй бид бүхэн өөрийн санасны дагуу болохгүй зүйлийг ч сэтгэл дундуур хүлээж авах хандлагатай байдаг.

Тариачин, малчин хүний хувьд хур бороо нь тэнгэрийн хишиг боловч хувцсаа хурдан хатаахсан гэсэн хүний хувьд, эсвэл аялалаар явж байгаа хүний хувьд хар усан бороо гэсэн сөрөг үзэгдэл болдог шиг бидний сэтгэл өөрсдийн нөхцөлд тааруулан хувирах нь олонтаа.

Гэхдээ “ингэж л битгий үзээрэй”, “яагаад ийм болчих воо” гэж дургүйлхэн бодлоо ч бодит байдал огтхон ч өөрчлөгдөхгүй. Тийм болохоор “ингэж л битгий үзээрэй” гэсэн сөрөг мэдрэмжээсээ түр холдож, бодит байдлыг хөндлөнгөөс түүнчлэн эерэгээр ажиглаад үзвэл ямар вэ? Аливаа зүйлийг харах өнцөг өөрчлөгдвөл сэтгэл санаа ч дагаад уужим болдог гэж бодож байна.

Миний хувьд биеийнхээ өвчнийг “адилхан өвчнөөр шаналж байгаа хүний сэтгэлийг ойлгож, тийм хүмүүст эелдэг хандахын төлөөх туршлагыг хуримтлуулж байна” гэж хүлээн авч байгаа. Түүнчлэн “хэрэв эдгэвэл өвчин шаналалгүй энгийн амьдрахыг хэзээ хэзээнээс илүүтэйгээр [талархалтай] гэж бодох нь гарцаагүй” гэж дотроо бодон, тийм цаг ирэхийг одооноос тааламжтай нь аргагүй хүлээж байгаа.

Өвчин, гэмтэл бэртэл хүнд үед заримдаа утга учиргүй зүйл шиг бодогддог. Гэтэл түүнийг эерэгээр хүлээж авч чадвал тэр мөчөөс эхлэн яг одоо мэдэрч байгаа өвдөлт, уйтгар гуниг зөөлрөөд зогсохгүй, хойшдын амьдралыг илүү утга учиртай болгох энергийг хуримтлуулж чадна гэж бодож байна.



Уужим сэтгэлээр амар амгаланг мэдрэх

Би дээр “тэнгэрийн хишиг хур бороо”, “хар усан бороо” гэсэн яриаг дурьдсан. Энэ бол бороо гэсэн нэг үзэгдлийг өөр өөрөөр харах ганцхан жишээ юм. Юмс үзэгдийг олон талаас нь харах үед ямар ч хүнд хэцүү нөхцөл байдал дотроос “талархууштай” гэж бодох хүчин зүйлийг заавал олж харж болно. Яагаад гэвэл энэ ертөнцөд хэрэггүй зүйл гэж нэгээхэн ч үгүй.

Бурханы шашин судлаач Кино Казүёши “бүхий л юмс үзэгдэл, амьдралд тохиох учрал нь үнэний төрхийг илэрхийлж байдаг” гэсэн “юмс үзэгдлийн жинхэнэ дүр төрх” хэмээх сургаал дээр үндэслэн “хүний төрөх, үхэхээс эхлээд хорвоо ертөнц дээр тохиолдох бүхий л зүйлсийг жинхэнэ төрх хэмээн эерэгээр хүлээж авах хэрэгтэй” гэж хэлсэн байдаг.

Өөрөөр хэлбэл бидний харж, сонсож, биеэрээ туулж байгаа бүхнийг Кино судлаачийн үгээр бол “эерэг эерэг, бас дахин эерэгээр” хүлээж авах гэдгээс өөрөөр ойлгох боломжгүй мэт санагдана.

Сая “хичнээн хүнд нөхцөл байдал дотроос ч [талархалтай] гэж бодох зүйлийг заавал олж харж болдог” гэж хэлсэн. Тэр утгаараа хичнээн хүнд хэцүү нөхцөл байдал нь ч амьдралыг баялаг болгох бэлэг бөгөөд бүх тохиолдож буй зүйлсийг эерэгээр хүлээн авах боломжтой гэж ойлгож болно. Гэхдээ мэдээж хүнээсээ, нөхцөл байдлаасаа шалтгаалаад тэр дор нь “талархалтай” гэж хүлээн авч чадахгүй зүйл байж болно.

Залуугаасаа л эцэг эхдээ талархдаг хүн байхад өөрөө үр хүүхэдтэй болоод эцэг эхийнхээ ачийг ухаардаг хүн ч байна. Үүн шиг хүн бүрийн анзаарч ойлгох хугацаа, түвшин ондоо юм.

Хэрэв аливаа зүйлийг эерэгээр харж чадахгүй байвал өөртөө дүгнэлт хийх дараах аргыг санал болгож байна. Бусдыг үгүйсгэж, буруутгах сэтгэлээсээ салж чадахгүй байгаа бол “нинжин сэтгэлээ мартсан юм биш биз?”. Харин үүссэн нөхцөл байдлыг эерэгээр хүлээж авч чадахгүй байгаа үед “даруу төлөв зангаа гэсэн юм биш биз?” гэсэн асуултыг өөртөө тавих хэрэгтэй. Хүн гэдэг зөвхөн өөрийнхөөрөө, аминч үзлээр аливаа зүйлийг харах үед нинжин сэтгэл, даруу төлөв байдлаа гээх гээд байдаг талтай.

Аливаа зүйлийг эерэгээр харах гэдэг нь уужим сэтгэлээр, амар жимэр амьдрах гэсэн үг юм. Эндээс л эерэгээр харах уу, сөргөөр харах уу гэдгийн аль нь илүү аз жаргалтай амьдрал вэ гэдэг нь тодорхой байна.

Косей сэтгүүл 3-р сарын дугаараас



Өөрт олгогдсон амьдралын даалгаврыг хүлээн авах нь

Риспё Косей кай,
Хойд Америк дахь олон улсын төв
Николас Озуна

Энэ илтгэл 2016 оны 10 сарын 30нд Лос-Анжелес нийгэмлэгт зохион байгуулагдсан үүсгэн байгуулагчийн мэндэлсэн өдрийн үйл ажиллагаан дээр тавигдсан болно.

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Түүнчлэн үүсгэн байгуулагчийн мэндэлсний 110 жилийн ойн мэндийг дэвшүүлье. Миний бие үүсгэн байгуулагчтай уулзсан учрал байхгүй ч үүсгэн байгуулагчийн сургаалаар дамжуулж, бурханы зам мөрт хөтлөгдсөөр өдийг хүрсэн билээ. 20 жилийн өмнө би анх РКК-д элсэн орсон бөгөөд анхнаасаа л гишүүн байгаагүй гэж ойлгож болно. Техас мужийн Сан-Антониод төрж өссөн би хүүхэд байхдаа Баптист сүмийн ням гарагийг сургуульд явдаг байв. Гэвч эцэг эх маань жинхэнэ сүсэг бишрэлтэй гэж хэлэхээргүй байсан тул би шашинд итгэх итгэлээ хэсэг хугацаанд алдсан юм. 12 настай байхдаа шашныг эсэргүүцэх болж, шашин бол утга учиргүй, мухар сүсэг гэж боддог болов. Тухайн үед миний итгэдэг зүйлс гэвэл шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоо, туршлага дээр үндэслэсэн баримт нотолгоо, эсвэл сурах бичиг дээр бичсэн зүйл байв.

Тэр нэг жилийн 8 сарын үд дунд ах маань өөрийн хүйсний талаар гэр бүлийхэндээ нэг зүйлийг дуулгав. “Миний доторх хүн үнэндээ эмэгтэй хүн. Гэхдээ би өдийг хүртэл эрэгтэй хүний дүрд тоглож, худлаа ярьсаар ирсэн” гэж тэр хэлэв. Ахын хэлсэн үгийг хүлээж авах бэлтгэл байхгүй байсан тул гэр бүлийнхэн бүгдээрээ гүн

цочролд орцгоов. Харин ах маань гадаад төрх, нэр түүнчлэн өөрийг нь эрэгтэй гэж харагдуулах бүхий л зүйлсийг солих гэж оролдож эхлэв. Аав маань тун ч эрэгтэйлэг хүн тул том хүүгээ хэрхэн өөрчлөгдөхийг харж тэвчихгүй, хүлээн авч чадахгүй байлаа. Ахыг зүгээр харж ч чадахгүй байсан бөгөөд ахтай ярих бүртээ өндөр дуугаар ширүүн ярьдаг байв.

Харин ээж ахад маш их санаа зовж байв. Миний хувьд ахаасаа их ичиж байсан тул хажууд нь байхаас зайлсхийж, ахтайгаа ямар ч харилцаа хамааралгүй байхсан гэж боддог болов. Сургууль дээрээ ч гэсэн ахыгаа таньдаггүй хүн шиг царайлж, үргэлж холуур явдаг байв. Тэр үед ах үсээ ургуулж, эмэгтэйлэг хувцаслаж, хүүхэлдэй, нүүрний будаг зэргийг сонирхож байсан юм. Ах маань өөрийгөө ойлгуулахын тулд байдгаараа хичээж байсан боловч бидний хувьд ахыг сэтгэцэд нь ямар нэг өөрчлөлт гарснаас зайлахгүй гэж бодож байв. Ээж маань ахыг буцаад хэвэндээ орж магадгүй гэж найдан, сэтгэл зүйч рүү дагуулан явдаг болов. Гэвч ах маань өөрийнхөө амьдралыг буруу байна, бас буцаж өмнөх хэвэндээ орох талаар ч бодохгүй байсан тул эмчилгээ үр дүн муутай байж, ямар нэг өөрчлөлт гарсангүй.

Гэр бүлийн маань өмнөх энх тунх байдал бүрэн алдагдав. Аав ах хоёр өдөр бүр маргалдаж, гэр бүлийнхэн бүгд тайван бус байдаг болов. Ээж маань гэр бүлийнхнийгээ эвтэй найртай байлгахын тулд янз бүрийн сургаал, тэр дундаа дорнын гүн ухааны сургаалыг хүртэл судалсан боловч тухайн үед учирсан сургаалууд нь бүгд өнгөцхөн, жинхэнэ өөрчлөлтийг авчрах зүйл биш байв. Тухайн үед би ахыгаа яагаад тийм болсныг огт ойлгохгүй байсан боловч аль болох түргэн гэр бүлийн таагүй уур амьсгал намжаасай гэж дотроо залбирч байв.

Тэгээд удаан хайж байсан, үнэн сэтгэлээсээ итгэж чадсан хариултаа сурах бичгийн нэг хуудаснаас олсон юм. Тэр нь дэлхийн түүхийн хичээл дээр хэрэглэдэг сурах бичиг байсан бөгөөд дорнын шашин болон буддын сургаалтай холбоотой хэсэг дээр богинохон боловч “хугагтын дөрвөн үнэн”-ийг тайлбарласан байв. Тэнд “амьдрал бол зовлон бөгөөд зовлонд шалтгаан бий. Сургаалын зам мөрийг дагах нь зовлонгоос гэтэлгэх зам мөн” гэж бичсэн байв. Би тэр богинохон тайлбарыг уншаад товчхон атлаа тэрхүү гүн гүнзгий утгад нь өөрийн эрхгүй татагдсан юм. Тухайн хэсэг миний хувьд “үнэн” гэж хэлж болох зүйл байсан бөгөөд логикоор ойлгож болох зүйл байлаа. Хорвоо ертөнцийн явдал



Лос-Анжелес нийгэмлэг дээр илтгэл тавьж буй гишүүн Озуна

түүнчлэн гэр бүлд минь тохиогоод байгаа асуудлын талаар бодох үед миний тойгой дотор үргэлж “хутагтын дөрвөн үнэн” байдаг байв. Буддизмын талаар улам гүнзгий судлах хүсэл надад төрөв.

Түүний дараагаар би буддизмтай холбоотой хэд хэдэн ном уншсан. Зовлонгоор дамжуулж суралцаад, эцсийн дүндээ аз жаргал руу хөглөж буй тухай сэдвүүдийг голчлон уншив. Гэвч буддизмаас суралцах гайхамшигийг мэдэрч байгаа хэрнээ сэтгэл маань ямар нэг зүйлээр дутаад байгааг мэдэрч байв. Шалтгаан нь буддын аль нэг байгууллага дээр очиж, үйл ажиллагааг нь биеэр мэдэрч үзэхийг хүссэнд оршиж байв. Ээж маань тухайн үед хараахан бүрэн итгэх шашинаа олоогүй байсан тул ойрхон байдаг Рисшё Косей Кай гэдэг японы жижигхэн буддизмын төв дээр очиж үзье гэж ээжийгээ ятгав. Ээжтэйгээ хамтдаа тус төв дээр очиж үзэхэд гишүүд нь бүгд Япон хүн байсан бөгөөд залуу хүн огт харагдахгүй байлаа. Дэг жаяг нь бүгд Англи хэл дээр явагдаж байсан тул дагаад хийсэн боловч утгыг нь огт ойлгоогүй юм. Гэвч миний хувьд тэр бүхэн асуудал биш байв. Учир нь тэрхүү төвийн уур амьсгал ээж бид хоёрт ихээхэн тайвшралыг мэдрүүлсэн ба биднийг халуун дотноор хүлээн авсан гишүүдийн нинжин сайхан сэтгэл бидэнд юу юунаас илүү сэтгэгдэл төрүүлэв. Тэр үед би дөнгөж 15 настай байсан бөгөөд тус төв дээр ердөө хэдхэн цаг болсон боловч өөрийнхөө хайж байсан зүйлийг олсон гэдгээ мэдэрсэн юм.

Тухайн үед Сан-Антонио салбарыг хариуцаж байсан бүх Америкийн сургаал түгээгч Накамүра Наоми гуай: “аливаа зүйлийг байгаагаар нь хүлээж авч чадвал аз жаргалыг гарцаагүй олох болно” гэж ярьсныг одоо хэрнэ тод санаж байна. Мөн үргэлжлүүлээд “бид бүгд хоорондоо холбоотой бөгөөд бүгд бурханлаг чанартай. Тиймээс бурхан багшийн нүдээр бид бүгд эрх тэгш юм” гэж айлдсан юм. Би тэр сургаалыг ахтайгаа ойлголцохын төлөө бурханаас надад зориулан илгээж байгаа дохио гэж хүлээж авсан. Миний хувьд тэр том нээлт байв. Тухайн үед өнгөцхөн ойлгосон боловч шашин шүтлэг нь оюун ухаанаараа ойлгох боломжтой зүйл юм байна гэдэг нь миний гайхшралыг төрүүлэв. Түүнчлэн зөвхөн оюун ухаанаараа ойлгож болох зүйлд нь итгэвэл хязгаар бий болох бөгөөд өөрийгөө жинхэнээсээ өөрчилмөөр байвал оюун ухаанаараа ойлгох төдийд хангалттай бус итгэл бишрэл бас хэрэгтэй гэдгийг мэдсэн юм.

Эргээд бодоход Мексик гаралтай Америк хүн болж төрсөн миний бие энэхүү японы жижигхэн байгууллагатай холбогдсон учралыг үргэлж гайхшран боддог байв.

Гэхдээ одоо бол, тухайн үед би бурханы сургаалыг хүлээж авах бэлтгэл хангагдсан учраас бурхан багш

намайг энэ газар луу дуудсан гэдэгт итгэдэг болсон.

Сургаал түгээгч Накамүра гуай “гэнэтийн тохиолдол гэж байдаггүй” гэж хэлдэг байсан. Түүнчлэн бүхий л учрал тохиолууд нөхцөл, шалтгааны хуулийн дагуу өрнөдөг бөгөөд бүхий л зүйлс болох ёстой болоод үүсдэг гэж заалгасан юм. Энэ бүхнээс үүдээд би ахдаа тохиолдсон асуудал болон гэр бүлийн асуудлууд бүгд үнэндээ бидэнд тохиолдох учиртай, шалтгаантай байсан юм байна гэдгийг ойлгов. Түүнчлэн дэлхийн түүхийн сурах бичиг дээр байсан “хутагтын дөрвөн үнэн”-ий тайлбарыг олж уншсан маань ч, сониноос Рисшё Косей Кайн зарлалыг олж харсан маань ч бүгд миний хувьд шаардлагатай, болох ёстой зүйлс байсан юм. Огтхон ч гэнэтийн эсвэл санаандгүй учрал байгаагүй. Бурхан багшийн билиг оюунд өөрийн мэдэлгүй хөтлөгдөн явж байсан гэж хэлвэл тохиромжтой байх.

Сургаалын зам мөрт шамдсаны үр дүн эхнээсээ гарч эхлэв. Нэг өдөр ээжтэй ярилцах зүйл гараад өрөө лүү нь очтол, ээж ах хоёр цугтаа байх нь хаалганы завсараар харагдав. Ээж ахын ард зогсоод толинд харж байв. Тэр орой зохион байгуулагдах ахын найрал хөгжмийн тоглолтонд зориулж ээж, ахад шинэ даашинз, гутал авч өгсөн байв. Тэгээд ахтай хамтдаа шинэ даашинз гутлаа өмсөж сонирхонгоо, ахын үсийг самнаж өгч байв. Чин сэтгэлээсээ ахыг байгаагаар нь хүлээн авсан ээжийнхээ байр байдлыг хараад хэлэх үггүй болов. Аливаа зүйлсийг байгаагаар нь хүлээж авах тухай сургаалыг ээж маань нухацтай хүлээн авч, хэрэгжүүлээд ахын бурханлаг чанарыг аль хэдийн олж харсан байв. Ээж маань хүмүүсийн үнэлэмж, зөв гэж боддог зүйлийг баримтлах гэж улайрахаа больж, харин ахын сэтгэлийг ойлгохоор нэг алхам урагшилсан байв. Тэр үед ахын сэтгэл ямар амгалан байсан нь тодорхой. Ээжийн хийсэн үйлдэл ахын төлөө байгаад зогсохгүй түүнчлэн гэр бүлийнхээ эв нэгдлийн төлөө гэдгийг би сайн ойлгож байв. Аминч үзлээсээ салсан ээжийн үйлдэлд өөрийн эрхгүй толгой бөхийн нулимс унагав. Түүнчлэн тэр мөчийг хүртэлх ахдаа гаргаж байсан үйлдлүүдээсээ ичив. Тэр өдрөөс эхлэн ахыгаа харах өнцөг өөрчлөгдөж, ахыгаа байгаа чигээр нь хүлээж авахаар шийдсэн юм.

Харин аавын сэтгэлд өөрчлөлт гарахад түүнээс илүү удаан хугацаа шаардагдсан юм. Гэхдээ аминч үзлээсээ салсан ээжийн байр байдал эцсийн дүндээ хатуу бодолтой аавыг хүртэл энэрэнгүйн сургаал руу хөтөлж чадсан. Хэдийгээр аав маань ахын амьдралын хэв маягийг хүлээн зөвшөөрөөгүй ч, ахыг энэрэнгүй сэтгэлээр хүлээн авдаг болсон юм. Аавын сэтгэлд ийнхүү өөрчлөлт гарсан нь бурханы сургаалыг хэрэгжүүлсний ач тус билээ. Ийнхүү гэр бүлийнхэн маань ахыг өөрчлөхийг оролдохоо больж,

байгаа чигээр нь хайрладаг болсноор ах маань өөрийгөө нуух шаардлагагүй болж, өөрийнхөөрөө байж чаддаг болсон юм. Гэтэл нэг өдөр ах маань гэнэт өөрийгөө эрэгтэй хүн гэдгээрээ хүлээн авахаар шийдэж, нэрнээс эхлээд хувцас, гадаад төрхөө бүгдийг хуучин байсан хэвэнд нь оруулсан. Гэхдээ энэ бүхэн ахын маань өөрийнх нь шийд байсан гэдгийг дурьдах хэрэгтэй байх.

Ах маань хуучин хэвэндээ ороогүй байлаа ч бид түүнд санаа зовохгүй байх байлаа. Учир нь бидний сэтгэл дотор гарсан өөрчлөлт хувирашгүй бат бөх байсан болохоор. Гэр бүлийн маань энэхүү өөрчлөлт намайг үнэхээр гайхшруулж, сургаалын хүчний гайхамшигийг анзаарахад хүргэсэн. Сургаал дарма зөвхөн судар дээр бичигдсэн үг төдий зүйл биш байлаа. Чин сэтгэлээсээ хэрэгжүүлвэл сургаал нь хүмүүсийн амьдралыг өөрчилж, яг одоо, байгаа газарт эв найрамдлыг үүсгэдэг. Би яагаад ингэж итгэж байна вэ гэхээр өөрийн нүдээр харж, биеэр мэдэрсэн учраас юм.

1999 он, үүсгэн байгуулагчийг бурхан болохоос яг 2 сарын өмнө “глобал залуучуудын уулзалт”-нд оролцохоор анх удаа японд ирээд байлаа. Ердөө л хоёр долоо хоногийн программ байсан боловч агуулга нь маш бүрэн дүүрэн, тэнд уулзсан олон гишүүд болон төвийн ажилчдын биеэ авч явах байдлаас бурханы шавь хүн ямар байх ёстой үлгэр дуурайлыг суралцсан юм. Болдогсон бол үүсгэн байгуулагчтай өөрийн биеэр уулзаж, талархалын сэтгэлээ илэрхийлээд, үнэт сургаалыг нь сонсьё гэж бодсон боловч тухайн үед үүсгэн байгуулагч эмнэлэгт хэвтэж байсан тул боломжгүй байлаа. Хэвтэж байгаа эмнэлэг нь бидний байрлаж байгаа байрнаас ойрхон байсан тул би алхаж очоод эмнэлэгийн хүлээн авах хаалганы гадна гараа хавсарган зогсов. Үүднийх нь гадаа зогсоод, үүсгэн байгуулагчийн талаар өдийг хүртэл сонссон зүйлсээ эргүүлэн бодонгоо, би ч гэсэн үүсгэн байгуулагч шиг хүн болохсон гэж хүчтэй хүссэн юм.

Их сургуульд явсан дараах 4 жилийн хугацаанд Сан -Антонио салбарын лидер гишүүний хувиар төрөл бүрийн үүргийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулахын хамтаар учирсан хүмүүстээ сургаалыг дамжуулж байв. Цагаан Лянхуа судрын “Номын багш 10-р бүлэг”-т заадагчлан энэ дэлхийд мэндэлсэн шалтгаан маань бурханы гар хөл нь болж, хүмүүст бурханлаг чанараа олж нээхэд нь туслах, хөтлөх үүрэгтэй гэдэгт гүнзгий итгэж, үүнийг өөрийнхөө амьдралын даалгавар болгосон юм. Би Техасын их сургуульд амьтан судлалын чиглэлээр суралцаж, амьтны эмнэлэгт (мал эмнэлэг) ажиллаж эхлээд байсан боловч эрт оройгүй буддизмын номлогч болохоор Токиод байрладаг Рисшё Косей Кайн Гакүрин сургуульд элсэн орох нь өөрийн явах ёстой зам гэдгийг сайн мэдэж байв. Их сургуулиа төгсөөд хэдхэн сарын дараа би Гакүрин сургуульд элсэн орж, РКК-н ажилтан болов. Японд очсоноосоо хойш дөрвөн жилийн хугацаанд өөрийн бүх бие сэтгэлээ дайчилж Цагаан

Лянхуа судрын талаар суралцсан. Гакүрин хонка (ажилтан бэлтгэх курс)-д орсон анхны Америк хүн байсан учраас хэл, соёл, амьдралын хэв маягийн ялгаанаас үүдэлтэй олон ч асуудлыг биеэрээ мэдэрсэн. Гэхдээ бурхан багшийн сургаал, мөн олон багш нарын заавар зөвлөгөөнөөс шинэ замыг нээхэд үргэлж ихээхэн хүчин чармайлт шаардлагатай гэдгийг ойлгосон юм. Хичээл чармайлтаа үргэлжлүүлж байтал өмнөх зам маань нээгдэж байгааг мэдэрч, надад тохиолдсон саад бэрхшээл бүхэн бүгд бурхан багшийн нигүүлсэл байсан гэдгийг анзаарсан юм.

4 жилийн хугацаанд бурханы сургаалд суралцсаны дараагаар миний бие 2 үүргийг хүлээн авсан юм. Нэгдүгээрт Флорида мужийн Клиер Уотарт байрладаг Юнитериан юниверсалистын нийгэмлэг дээр дадлагын гүйцэтгэгчийн албыг хашигаа нийгэмлэг дотор РКК-н салбарыг байгуулж, салбарын ахлагчаар ажиллах байв. Юнитериан нийгэмлэгийн хүмүүстэй үйл ажиллагаагаа хамт явуулах нь үнэхээр үр өгөөжтэй, суралцах зүйл ихтэй туршлага болсон юм. Тэнд би РКК дотор байхдаа суралцаж чадаагүй, Америк хүмүүсийн байр суурьнаас харсан сүм, нийгэмлэгийг удирдан зохион байгуулах арга барилаас суралцсан. РКК, Юнитериан юниверсалистын нийгэмлэгийн хамтын үйл ажиллагаа нь анх удаа байсан бөгөөд Америк хүмүүс шашин шүтлэгээс юуг хүсдэгийг гүнзгий судлах боломж гарсан нь миний хувьд маш утга учиртай байлаа.

Танпа байд шинээр байгуулсан хэсэг маань надаас өөр гишүүнгүй жижигхэн газар байсан боловч Юнитериан юниверсалистын нийгэмлэгийн зохион байгуулалтаас үлгэр авч, Англи хэл дээр шинэ хэв маягтай дэг жаягийг нэвтрүүлснээр олон талаараа хөгжин дэвшиж чадсан юм. Салбар хурдацтай хөгжиж байсан боловч миний хувьд хангалттай гэж бодохгүй байв. Үйл ажиллагаагаа эхлүүлсний 2 дахь жилийн нэгэн өдөр, ном уншлагын дараа гишүүдийн тоо өөрийнхөө гаргасан зорилтот тоонд хүрээгүй байгаад цочирдож, мөн гол ажлыг нугалдаг хоёр лидер маань нүүгээд өөр газар луу явсан зэргээс улбаатайгаар сэтгэлийн гүн хямралд оров. Тэвчээртэй байх ёстой гэдгээ ойлгож байсан боловч сэтгэлийнхээ хаа нэгтээ өөрийнхөө зүтгэлийн үр шимийг хүлээгээд байв.

Бусдаас нууцалж байсан боловч тухайн үед миний санаа үргэлж зовдог байв. Энэ үед толгойд гэнэт судар унших санаа орж ирэв. Хүмүүст судар уншихыг байнга зөвлөдөг байсан хэрнээ би өөрөө хааяа л судраа уншдаг байв. Үүнийгээ засах ёстой гэдгээ ухамсарлаж байсан тул тэр өдрөөс эхлэн өдөр бүр, маш удаан хэмнэлээр, анхаарлаа төвлөрүүлэн судраа уншихаар шийдсэн юм. Өдөр бүр судраа ингэж уншсаад хэдэн долоо хоног өнгөрөхөд миний доторх санаа зовинол аажмаар алга болж байгааг анзаарав. Нэг орой судраа уншиж байхдаа шинэ гишүүдийн тоо том асуудал биш гэдгийг ойлгов. 10 гаруйхан гишүүнтэй байлаа ч гишүүд нийгэмлэг дээр

ирэхэд нь би хүн тус бүрт талархаж, бурханы сургаалаас суралцахад нь багахан ч гэсэн тус болохоор бүх бие сэтгэлээ дайчлах нь чухал. Гишүүд үүнийг надад ойлгуулахын төлөөх учрал юм гэдгийг ухаарсан юм. Флоридад өнгөрүүлсэн 4 жилийн хугацаанд номын андуудынхаа төлөө зүтгэж хийсэн бүхэн маань хэдий алдаа эндэгдэл, туршилтаар дүүрэн байсан боловч үнэлж барашгүй туршлага болсон. Ийнхүү аливаа зүйлийг хүлээж авах үзэл баримтлалаа арай хийж оллоо гэж бодож байтал, Лос-Анжелесын РКК Хойд Америкийн Олон улсын төв рүү шилжүүлэх шийд төвөөс гарав.

Лос-Анжелест юуг хийж гүйцэтгэх ёстойгоо эхэндээ сайн мэдэхгүй байсан боловч юуны түрүүнд дөнгөж бий болоод байгаа унаган Америк гишүүдийн түшиг тулгуур нь больё хэмээх бодол надад байв. Эхнэр бид хоёрыг номын андууд маань уриалгахан хүлээн авсан бөгөөд тэдэнтэй богино хугацаанд маш дотно болов. Яг л олон жил хамтдаа байсан андууд шиг байв. Номын андууд маань улам хөгжиж, шинэ зүйлсийг туршиж байгааг нь харахаар эрч хүч оргилон ирдэг байв. Мөн залуучуудын бүлгийн үйл ажиллагаанаас ч эрч хүчийг авдаг байлаа. Энэ бүгд миний хувьд тун ч шинэлэг зүйлс байлаа. Эхнэр Чикагийн хувьд Флоридад байхад, мөн Лос-Анжелес руу нүүх үед ч амар байгаагүй болов уу. Гэвч нэг ч удаа гомдоллож байгаагүй ба намайг өөрийн замыг хайн эрэл хийж явахад үргэлж зөв зам руу чиглүүлэх хамгийн сайн багш байсан юм. Эхнэрийнхээ сургаал номонд хандсан чин сэтгэлээс би үргэлж эрч хүчийг авдаг. Эхнэр маань арын албанд хамгийн их үүрэг гүйцэтгэсэн хүн бөгөөд юмыг байгаагаар нь хүлээж авч чаддаг болохоор л Америк дахь Японы поп дуучин болохоор өдийг хүртэл тэмцэж ирсэн болов уу.

Лос-Анжелест номын андуудтайгаа бурханы сургаалаас суралцахын баяр хөөрийг амтлахын хажуугаар эрүүл мэндийн тал дээр нэлээд асуудлыг биеэр туулав. Өнгөрсөн жилийн эхлэлээс төрөл бүрийн өвчин, огцом бие муудах асуудлууд надад ар араасаа тохиолдох болов. Тэр дундаас хамгийн хүнд байсан нь юм залгихад хөндүүрлэх байсан бөгөөд хоол сайн идэж чадахгүй байв. Ходоод хямарч, хоолны нарийн дэглэм барих шаардлагатай болов.

Эхнэр бид хоёр ярилцаад, хадам ээжээсээ үлгэр дууриал авч, сар бүрийн амин өдрийн номын уншлага, үйл ажиллагааг гэртээ хийж байхаар болов. Хадам ээж маань амин өдрийн номын уншлагыг сар бүр таслалгүй 20 жилийн турш гэртээ хийж ирсэн бөгөөд тэр хугацаанд эрүүл мэнд, аз жаргалаар дүүрэн амьдарч ирсэн болохоор тэр байлаа. Завгүй үе олонтаа тул жаахан төвөгшөөх үе хааяа байсан боловч энэхүү хэрэгжүүлэлтээр дамжуулж, нүдэнд харагдахгүй ертөнцийн сүсэг бишрэл улам гүнзгийрсэн. Залгиурын бэрхшээлээр дамжуулж, би өөртэйгөө тохиолдсон учрал

тохиол бүрээс хангалттай суралцаагүй, өөрөөр хэлбэл тэр бүхэнд хангалттай талархаж чадаагүй гэдгээ ойлгосон юм. Ийнхүү ухаарсан мөчөөс өмнөх шигээ юм хэвийн иддэг болсон. Эрүүл болоод хамгийн түрүүнд идсэн Такос ямар амттай байсан гээч.

Сонирхолтой нь миний биеэрээ мэдэрсэн дээрх өвчний шинж тэмдэгээр өвөг дээдэс маань ч гэсэн амьд ахуйдаа шаналж байсан юм. Ийнхүү адилхан зовлонг мэдэрснээр өвөг дээдэстэйгээ холбогдох холбоос маань улам хүчирхэгжиж, тэдэндээ өмнөхөөсөө ч илүү талархдаг болсон гэж бодож байна. Өвчин маань илааршсан нь үүнтэй холбоотой болов уу. Амин өдрийн номын үйл ажиллагааг гэртээ хийсэн хэдэн жилийн хугацаанд янз бүрийн шинж тэмдэгүүд илэрсэн ч хэсэг хугацааны дараа алга болж байв. Эдгээр нь бүгд адилхан шалтгаанаар шаналж байгаа хүмүүсийн сэтгэлийг ойлгох, тэдэнд эелдэг зөөлөн ханддаг хүн болгохын төлөөх надад хэрэгтэй туршлага байсан гэж бодож байна. РКК-тай учраагүй бол ингэж бодож, хүлээж авч чадахгүй байсан болов уу. Би энэхүү номын андуудынхаа нэг гишүүн болсондоо чин сэтгэлээсээ талархаж байна.

Ялангуяа Фүкүшима шүнин (хэсгийн ахлагч)-ээс эхлээд Өмнөд Бэйн нийт гишүүдийн халуун дэмжлэгт талархаж байна. Мөн та бүхэн амин өдрийн номын уншлагад идэвхтэй оролцож, сургаал, зөвлөгөөгөө өгөж байгаад чин сэтгэлээсээ талархаж байна. Лос-Анжелесын номын андууд бол миний гэр бүл юм. Энэ хүртэл зам мөрт хөтлөгдөн ирсэн маань огтхон ч санаандгүй зүйл биш. Түүнчлэн хойшид ч гайхалтай учралууд хүлээж байгаад эргэлзэх зүйл алга.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.



Лос-Анжелес нийгэмлэгийн залуучуудын бүлгийн найзуудын хамтаар (Арын эгнээ, зүүн гар талаас хоёр дахь нь)

Охин дүүтэй болсноос хойш том охин маань эрхлээд байдаг болчлоо?



Q

Бага охин маань төрсний дараа, дүүгийнхээ арчилгаанд туслах гэж хичээдэг байсан том охин маань сүүлийн үед гэнэт эрхлээд байдаг болчлоо?

A

Хүүхдүүдээ явал сайн хүмүүжүүлэх вэ гэж үргэлж санаа тавьдаг мундаг ээж байна.

Дүүтэй болмогцоо ах, эгч нь “эрхлээд, эргээд жаахан хүүхэд шиг байх гээд байна” гэсэн асуудал бараг айл болгонд тохиолддог гэж хэлэхэд хилсдэхгүй. Ээжийнх нь бүх хайр дүү рүү нь шилжчихлээ гэж бодоод, санаа нь зовдог байх нь. Тийм учраас л “өөртөө анхаарлыг татахын тулд” нялх хүүхэдтэй адилхан мөөмөө идэх гэх, живх хэрэглэх гээд өмдөндөө шээх зэргээр аашилж болно.

Энэ бүгд ээжээсээ “хайр нэхэж байгаа дохио” гэж ойлгож болно. Аль болох хүүхдэдээ хүрэх, тэврэхийг хичээж, хангалттай “хайраар цэнэглэх” хэрэгтэй. Мөн том охиндоо “эгч нь юм байж тэвчих хэрэгтэй” гэдэг үгийг их хэрэглэж байгаа юм биш биз? Хоёрын хоёр хүүхэд өсгөж байгаа ээж завгүй учраас том охиндоо “эгч нь юм байж” гэсэн үгийг их хэлэх хандлагатай байдаг. Ингэж хэлэхийнхээ оронд гэрийн ажилд туслах, сайн зүйл хийсэн үед нь “эгч хүн гэсэндээ аргагүй л өөр байна шүү” гэж магтаарай.

Дүүгийнх нь арчилгаанд туслуулж ч болно. Жишээлбэл живх солих үед нэг талын наалтыг нь эгчээр нь наалгуулах, сүү уулгахдаа эгчтэй нь хамтдаа өгөх зэрэг байж болно. Ийм үед эгчид нь “дүү нь эгчдээ баярлалаа” гэж хэлж байна. Миний охин ч гэсэн нялх байхдаа ингээд ээжийнхээ мөөмийг зөндөө идсэн. Ээж нь охиндоо маш их хайртай шүү” гэж хэлээд чанга тэврэх хэрэгтэй.

Хүүхэд ээжийнхээ хайрыг л хүсээд байгаа нь тэр юм. Сэтгэл нь ханавал ээжийн хүссэн “ах”, “эгч” болъё хэмээн хэрэндээ хичээх болно.

Хүүхэд өөрийнхөө хэмжээнд чадлаараа хичээж байдаг. Тиймээс заримдаа “яг одоо зөвхөн чиний ээж” гэсэн сэтгэлээр том хүүхэдтэйгээ тоглох цаг гаргах нь чухал. Тийм цаг богинохон байсан ч болно. Гол нь ээж та чин сэтгэлээсээ тогловол хүүхдийн тань сэтгэл ханах нь гарцаагүй. Хүүхдийн хувьд хамгийн хайртай хүн бол яах аргагүй ээж юм.



Point Хүрэх, тэврэхийг хичээцгээ

Дүүтэй болмогц нь том хүүхдээ шууд л “эгч”, “ах” болгох гээд байдаг. Гэтэл тэд ч гэсэн хараахан эрхэлдэг насан дээрээ л байгаа. Зөвхөн том хүүхэдтэйгээ өнгөрүүлэх цагийг гаргацгаая.

Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт

Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт нь “Эцэг эх өөрчлөгдөх юм бол хүүхэд ч гэсэн өөрчлөгдөнө” гэсэн сурган хүмүүжүүлэх арга ухаанд тулгуурлан газар газарт сургалт семинар зохион байгуулж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх талаар зөвөлгөө өгч байна. Үүгээр дамжуулан олон хүмүүс хүүхдээрээ дамжуулан гэр бүл гэж ямар байдгийг суралцаж, аз жаргалтай гэр бүл олноор төрж байна.

Эхийн хайр

Нивано ерөнхийлөгч “хүний хамгийн дээд түвшин бол сэтгэл нь үргэлж энэрэл нигүүлсэлээр дүүрэн байх явдал” гэж айлдсан байдаг. (“Зурх сэтгэлийн мэлмийгээ нээх нь”) 176х

Хоёр хүүхэдтэй эх хүний хувьд хүүхдүүдээ асрах өдөр бүрийн үйл нь бусдын төлөө гэсэн энэрэл нигүүлсэлийн сэтгэлээр дүүрэн байдаг буй за.

Том охин тань ээжийгээ өөрт нь хэр их хайртайг мэдэхийг хүсчээ дээ. Тийм учраас яг ийм үед нь хайраа илэрхийлэх үгийг сайн хэлэх нь чухал юм.

Бурханы сургаалд “дөлгөөн төрх, хайрын үг” гэсэн хэлц үг байдаг. Утга нь тайван дөлгөөн харцаар инээмсэглэж, халуун дулаан үг бусдад хэлэхийг илэрхийлж байгаа юм.

Том охиндоо хэзээ хэзээнээс илүүтэйгээр инээмсэглэж, халуун дулаан үг хэлээрэй. Тэрхүү инээмсэглэл, үгний хүчээр том охин тань өөрийгөө хайрлуулж байгаа гэдгээ мэдэрч, цовоо сэргэлэн болоод эгч хүн шиг байхыг хичээх нь гарцаагүй.

Рисшо Косей Кай нийгэмлэгийн сургалтын алба



Please give us your comments!



We welcome comments on our e-newsletter Living the Lotus.

living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Миний өмнөх хүн Будда бурхан

Саяхан Бангкок руу томилолтоор явах үед онгоц дотор болсон явдал. Миний урд талын суудал дээр суусан дунд эргэм насны эрэгтэй онгоц хөөрөв үү гүй юу суудлаа огцом хойш нь хэвтүүлчихэв. Нислэгийн гэрэл унтраагүй байсан болохоор “аюултай зүйл хийж байна даа”, “яасан ёс суртахуунгүй хүн бэ” гэж бодон бага зэрэг бухимдсан би өөрийгөө тухгүй, ямар хэцүү нөхцөлд байгаагаа тэр эрэгтэйд мэдүүлье гэж эхлээд бодов. Гэвч миний хажуу талын суудал хоосон байсан болохоор тийшээ шилжихээр шийдэв.

Суудлаа сольтол янз бүрийн бодол толгойд эргэлдэж эхлэв. “Би ч гэсэн энэ хүн шиг бусдад төвөг удах зүйл их хийж байсан байх даа”, “одооноос эхэлж, өөрийнхөө үйлдэл, бусдад үзүүлэх нөлөөнд илүү анхааръя”, “бусдын үйлдэл санаанд нийцэхгүй болмогц уурлаж бухимддаг зантай би бээр, ямар ч учрал тохиолыг сайн тал руу хувиргах аргад суралцсан нь үнэхээр талархмаар”. Ингэж бодтол урд талын суудал дээр бөх гэгч нь унтаж буй эрэгтэйн царай надад Будда лугаа харагдав.

3 сарын 5 бол Рисшо Косей кай нийгэмлэг байгуулагдсаны ойн баяр юм. Косей кайтай учирснаар миний амьдрал үнэхээр аз жаргалтай болсон. Үүнд чин сэтгэлээсээ талархаж байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Мизүтани Шёокоо

Рисшо Косей Кай



Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2017

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles
CA 90033 U.S.A

Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.

Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261

e-mail: rkseattle@juno.com

http://www.buddhistLearningCenter.com

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.

Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745

e-mail: dharmasanantonio@gmail.com

http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.

Tel: (727) 560-2927

e-mail: rktampabay@yahoo.com

http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.

Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633

e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.

Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.

Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.

Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567

e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.

Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437

e-mail: info@rksf.org http://www.rksf.org

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.

Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499

e-mail: rkny39@gmail.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.

Tel: 1-773-842-5654

e-mail: murakami4838@aol.com

http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai of Fort Myers

http://www.rkftmyersbuddhism.org/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.

Tel & Fax: 1-405-943-5030

e-mail: rkokdc@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

1660 Portland St. Klamath Falls, OR 97601, U.S.A.

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204, U.S.A.

Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,

CEP 04116-060, Brasil

Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Fax: 55-11-5549-4304

e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,

CEP 08730-000, Brasil

Tel: 55-11-5549-4446/55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongzheng District, Taipei City 100, Taiwan

Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

http://kosei-kai.blogspot.com/

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,

Taichung City 401, Taiwan

Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan

Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea

Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696

e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea

Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,

North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949
e-mail: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France

International Buddhist Congregation (IBC)

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibt-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami, Tokyo, 166-8537, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division**Rissho Kosei-kai of Central Delhi**

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,
110060, India

Rissho Kosei-kai of West Delhi

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka
New Delhi 110075, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Singapore**Rissho Kosei-kai of Phnom Penh**

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu**Rissho Kosei-kai Dhamma Foundation, Sri Lanka**

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralessgamuwa, Sri Lanka
Tel & Fax: 94-11-2826367

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Other Groups**Rissho Kosei-kai Friends in Shanghai**